

УЛСЫН ОНЦ ЧУХАЛ ОБЪЕКТЫГ ХАМГААЛЖ ИРСЭН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ, УЛСЫН ОНЦ ЧУХАЛ ОБЪЕКТЫН НЭРШЛИЙН ТУХАЙ

THE HISTORICAL TRADITION OF GUARDING STATE STRATEGIC FACILITIES

Т.Хүрэлбаатар

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Гэмт явдал, цагдаа, дотоодын цэрэг судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан-багш, бригадын генерал

T.Khurelbaatar

Senior researcher of institute of Ceiminology and Police Studies, United Research Institute, University of the Internal Affairs, Mongolia, brigader general

Э.Хандармаа

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Гэмт явдал, цагдаа, дотоодын цэрэг судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан-багш, цагдаагийн дэслэгч

Khandarmaa Erdenebayar

Researcher-teacher of Criminology, Police and Internal Troops Studies Center, Police lieutenant

*хариуцлагатай зохиогч: khanda0321@gmail.com

Хураангуй: Улс орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, улсын хилийн халдашгүй дархан байдалд ямар нэгэн халдлага, түрэмгийлэл бий болох, терроризм гарах орчин нөхцөл бүрдэхээс урьдчилан сэргийлэх талаар Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд байнга анхаарч ажиллаж байна.

Дэлхийн улс орны цэрэг, улс төр, нийгэм эдийн засгийн байдал улам бүр даяаршин үйлдвэр, техник технологийн өндөр хөгжил дэвшилд хүрч байгаа өнөө үед өөрийн эх орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд шинэ агуулга, өвөрмөц байдлаар хандах зайлшгүй шаардлага тавигдах болсон бөгөөд

Дотоодын цэргийн байгууллага нь Төр засаг, яам, командлалаас даалгасан үүргүүдийг түүхэн хөгжлийнхөө он жилүүдэд “Онц чухал объект”-д хамаарах ямар ямар объектуудыг хамгаалж ирсэн түүхэн уламжлал нь Цэрэг, армийг цомхотгох ажлын хүрээнд Дотоод явдлын яамны сайдын 1953 оны 6 дугаар сарын 19-ны өдрийн тушаалаар “Тусгай хороо”-г “Тусгай батальон”, “Хуяглан хамгаалах хороо”-г, “Харуул хамгаалалтын тусгай хороо” болгон тус тус өөрчлөн зохион байгуулж дотоодын цэргийн хамгаалалтад байгаа объектуудыг “Улсын онц чухал объектууд”, “Гарнизоны объектууд”, “Гарнизоны хуяглан хамгаалах объектууд”-гэж ангилж, зөвхөн улсын онц чухал объектуудын хамгаалалтыг тусгай батальонд хариуцуулж байжээ. Улсын онц чухал объект гэсэн нэр томъёо хэдий үеэс эхэлж хэрэглэгдэн алба ажиллагаанд нэрлэгдэн хэрэглэгдэж ирснийг судлан үзлээ.

Abstract: Organizations with special mandates to ensure the national security of Mongolia are constantly working to prevent any threats, aggression, or terrorism that may endanger the country's independence, territorial integrity, and the inviolability of national borders.

In today's world, where global military, political, social, and economic conditions are becoming increasingly interconnected and where industrial and technological advancements are rapidly progressing, it has become imperative to approach the protection of one's nation's independence and territorial integrity with new perspectives and specific characteristics.

The Internal Troops organization has historically been tasked by the government, ministries, and command structures to safeguard various “critically important objects.” As part of the downsizing of the military and armed forces, by Order No. A/63 of the Minister of Internal Affairs dated June 19, 1953, the “Special Detachment” was reorganized into the “Special Battalion,” and the “Armored Protection Detachment” and “Special Guard Detachment” were restructured. Under this reorganization, the facilities under the protection of the internal troops



Улсын Онц Чухал Объектыг Хамгаалж Ирсэн Түүхэн Уламжлал



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠳᠣᠲᠤ ᠠᠶᠳᠤᠯ ᠶ᠋ᠠᠮᠤᠨ ᠰᠠᠶᠳᠤᠨ ᠴᠢᠷᠭᠢᠨ ᠴᠢᠳᠠᠭᠠᠯᠠᠲᠤ

were classified as “Nationally Critical Facilities,” “Garrison Facilities,” and “Armored Garrison Facilities.” The Special Battalion was assigned the responsibility of guarding only the nationally critical facilities.

We have studied when exactly the term “nationally critical facility” was first introduced and began to be used officially in operations.

Түлхүүр үгс: Улсын онц чухал объект, Дотоодын цэрэг, түүхэн уламжлал, хамгаалалт

Keywords: State Critical Infrastructure, Internal Troops, Historical Tradition, Security

Нэг: Төр засгийн удирдагчдыг Дотоодын цэрэг хамгаалсан нь:

Монгол Улсын Дотоодын цэргийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дүгээр зүйлд “Үндэсний аюулгүй байдлыг хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд хангах Төрийн цэргийн байгууллагыг Дотоодын цэргийн байгууллага гэнэ” гэж хуульчлан заажээ. Дотоодын цэргийн байгууллага нь анх байгуулагдсан цаг үеэсээ эхлэн Улс орны чухал үүрэг бүхий албан газрууд, шорон гянданг цагдан манах, хоригдол, ялтанг хуяглан хүргэж хамгаалах алслагдсан хошуу нутгуудад нууц бичиг баримтыг хүргэх, дотоодод гарсан бослого хөдөлгөөнийг дарахад бие даан болон дотоодыг хамгаалах газрын алба хаагчидтай хамтран ажиллах зэрэг үүргийг голчлон гүйцэтгэж байсан байна.

МАХН-ын Төв хорооны нарийн бичгийн дарга нарын 1932 оны 6 дугаар сарын 16 хурлаас МАХН-ын Төв хороо, МХЗЭ-ийн Төв хороо, Засгийн газрыг Дотоодын цэргийн хамгаалалтад шилжүүлсэн.

Дотоод Явдлын Яамны сайдын 1941 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 750 дугаар тушаалаар Маршал Х.Чойбалсангийн Их тэнгэр дэх өвлийн байрыг хамгаалах шинэ үүргийг Дотоодын цэрэгт хүлээлгэжээ.

Дотоод явдлын яамны сайдын 1946 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн 526 тоот тушаалаар (Хүрэлбаатар, 2022, хууд. 179) Ерөнхий сайд, Улсын Бага Хурлын Төлөөлөгчдийн дарга, Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга нарын ажлын байр /Засгийн газрын ордон/, гэр орон, Баянгол дахь зуслан зэрэг объектууд, Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хороо, Улс Төрийн Товчооны 1954 оны 51/306 дугаар

тогтоол, Дотоод явдлын яамны сайдын 1954 оны 913 тоот тушаалаар (Хүрэлбаатар, 2022, хууд. 152) Х.Чойбалсангийн бунхан, Ерөнхий сайдын өвөл, зуны өргөө, Их тэнгэрийн аман дахь зочдын байр, Бага тэнгэрийн аман дахь хүнсний лаборатори, Цэргийн ба Нийгмийг аюулаас хамгаалах хэрэг эрхлэх яамны сайдын 1957 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 711 тоот тушаалаар (Хүрэлбаатар, 2022, хууд. 260) Төрийн ёслол, хүндэтгэлийн үүрэг (энэ үүргийг 1959 оны 7 дугаар сар хүртэл гүйцэтгэсэн) 1962 онд Их тэнгэрийн аман дахь Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хороо, Засгийн газрын 50-ын 3 дугаар зочдын байрны хамгаалалтыг Дотоодын цэргийн хамгаалалтад шилжүүлж, мөн манай оронд айлчлан ирж байгаа гадаадын төр, засгийн тэргүүн, дээд хэмжээний хүндэт зочид, төлөөлөгчдийн байрлаж байгаа байр, хөлөглөж яваа онгоц, галт тэрэг, автомашиныг нь хамгаалах үүргийг давхар даалгасан байна.

Тус алба 1932-1996 оны хооронд МАХН-ын Төв хороо, Засгийн газрын ордон, Төр засгийн тэргүүн нарын өргөөг хамгаалж байгаад, Монгол Улсын Их Хурлаар “Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль” батлагдан, хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан, уг үүргийг Төрийн тусгай хамгаалалтын газарт шилжүүлжээ. Тэгэхээр Дотоодын цэргийн алба нь монгол төрийн тусгай хамгаалалтын нэн хариуцлагатай зарим чиг үүргийг 64 жилийн хугацаанд хэрэгжүүлэн ажиллаж ирсэн түүхтэй ажээ.

Хоёр: Улсын үйлдвэр, албан газрыг дотоодын цэрэг хамгаалсан нь:

Монгол Улсын Үндсэн хууль 1960 онд шинэчлэн батлагдав. Үндсэн хуулийн хэрэгжилтийг хангахын хүрээнд манай орны хөгжил, цэцэглэлтэд үнэтэй хувь



нэмэр оруулах, эдийн засгийн онцгой ач холбогдол бүхий уул уурхай, цахилгаан станц, үйлдвэр, завод олноор байгуулагдаж эхлэв.

Шинээр байгуулагдсан үйлдвэр, завод, албан газруудыг Дотоодын цэргийн хамгаалалтад шилжүүлэх тухай төр засгийн шийдвэр гарч, улс орны хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтад дотоодын цэргийн гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдсэн байна. Үүнтэй уялдуулан Нийгмийг аюулаас хамгаалах яамны сайдын 1961 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 403 тоот тушаалаар (Хүрэлбаатар, 2022, хууд. 291) Нэгдүгээр цахилгаан станц, Сайд нарын зөвлөлийн 1974 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 147 дугаар тогтоолыг үндэслэн, Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны сайдын мөн оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 469 тоот тушаалаар (Хүрэлбаатар, 2022, хууд. 221) Сэлэнгэ аймгийн Бугант дахь (албан баримт бичигт Толгойт гэж нэрлэдэг) алтны үйлдвэр, Сайд нарын зөвлөлийн 1978 оны 439 дүгээр тогтоолоор (Хүрэлбаатар, 2022, хууд. 341) Дархан хотын болон 3 дугаар цахилгаан станц, Дорнод аймгийн Чойбалсан хотын цахилгаан станц, Сайд нарын зөвлөлийн 1978 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 223 дугаар тогтоолыг (Хүрэлбаатар, 2022, хууд. 340) үндэслэн Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны сайдын мөн оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 569 тоот тушаалаар (Хүрэлбаатар, 2022, хууд. 358) Эрдэнэт Уулын Баяжуулах Үйлдвэр, Сайд нарын зөвлөлийн 1983 оны 35 дугаар тогтоолын (Хүрэлбаатар, 2022, хууд. 362) дагуу 4 дүгээр цахилгаан станцын хамгаалалтыг хүлээн авч, хариуцан гүйцэтгэсэн байна.

Манай оронд цагаан морин жилд буюу 1990 онд өрнөсөн ардчилсан хувьсгалын үр дүнгээр төр засгийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орж, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1990 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 192 дугаар тогтоолоор (Хүрэлбаатар, 2022, хууд. 366) “БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Улсын цагдан сэргийлэх ерөнхий газар”-ыг байгуулахад түүний бүтцэд Дотоодын цэрэг шилжиж урьдын адил

улсын онц чухал объект болох “Их тэнгэр дэх цогцолбор” төр засгийн тэргүүдийн орон байр, дулааны цахилгаан станцууд, гяндан, онцгой, чанга дэглэмтэй хорих ангиуд, Урьдчилан цагдан хорих төв зэрэг объектуудын хамгаалалтыг хугацаат цэргийн албан хаагчдын хүчээр гүйцэтгэж байлаа.

Улсын Их хурлаар 1992 онд шинэ Үндсэн хууль батлагдсан бөгөөд Үндсэн хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн шинэчлэлийн ажлын хүрээнд 1995 онд Дотоодын цэргийн тухай хууль батлагдаж, түүхэнд анх удаа дотоодын цэргийн үйл ажиллагааны зарчим, гүйцэтгэх чиг үүрэг, алба хаагчийн эрх зүйн үндэс хуульчлан баталгаажжээ. Уг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэгт “Улсын Их Хурлаар 2017 онд шинэчлэн баталсан Дотоодын цэргийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т Дотоодын цэргийн хамгаалалтад байх улсын онц чухал объектын жагсаалт”-ыг Засгийн газар батална гэж тус тус заажээ. Хуулийн эдгээр заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор дотоодын цэргийн хамгаалалтад байх Улсын онц чухал объектуудын жагсаалтыг Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 135 дугаар тогтоол, 2017 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 281 дүгээр тогтоолоор батлуулан мөрдөж байна.

Засгийн газрын тогтоолд заасны дагуу Монголын Үндэсний Радио Телевизийн хэрэг эрхлэх газар, эфирийн студи, Монцамэ агентлаг, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Чойбалсан, Ховд, Даланзадгад хотын төвлөрсөн усан сан, өргөх байгууламж, Ховд, Говь-Алтай аймаг дахь усан цахилгаан станц, Баян-Өлгий аймаг дахь Цагаан нуурын чөлөөт бүс, Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр, Стандарт хэмжилзүйн Үндэсний төв, Цагийн эталон, Изотоп төв, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн төв лаборатори, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн лаборатори, Биокомбинат, Зооноз төв, Өмнөговь аймгийн Цагаан хад суурьшлын бүс, Улаанбаатар хотын II, III, IV дүгээр дулааны цахилгаан станцууд зэрэг улс орны нийгэм, эдийн засгийн нэн чухал ач



ᠬᠤᠭᠤᠯᠤᠯᠤᠰᠤ ᠰᠠᠬᠢᠭᠣᠯᠠᠬᠤᠢ

холбогдол бүхий объектуудыг хамгаалж, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай нягт харилцан ажиллагаатайгаар хамтран ажиллаж байна. Энд нэг тодруулга хийхэд, Улаанбаатар хотын цэвэр усны хангамжийн объектыг 1959-1993 он хүртэл цагдаагийн байгууллага хамгаалж байгаад, 1993 оны 7 дугаар сараас дотоодын цэргийн хамгаалалтад шилжүүлсэн.

Гурав: Хорих байгууллагыг дотоодын цэрэг хамгаалсан нь:

Дотоодын Цэрэг байгуулагдсан цагаасаа эхлэн хэрэгтэн, ялтанг харгалзах, шорон, гянданг хамгаалах үүрэг гүйцэтгэж ирсэн бөгөөд, 1950-иад оны эхэн үе хүртэл гол төлөв Дотоод явдлын яамны хорих байр, төв хорихыг хамгаалж байжээ. Харин энэ цаг үеэс ялимгүй өмнөх үе болох 1947-1953 онд Төв хорих, Цагаан хуаран, Амгалан, Хужир булан, Налайх, Мах комбинат, Зүүнхараагийн зэрэг хорих лагериудын 50 гаруй объектыг өдөр бүр 148 постоор хамгаалж байсныг дурдах нь зүйтэй.

Гэвч Хүн хүч хүрэлцэхгүй байсан тул 1949 онд Хүүхдийн колони, Салын рам, Үдлэг, Баянгол, Ерөө зэрэг 9 салбарыг, 1950 онд Рашаант, Цагаан-Эрэг, Зүүн хараагийн салбаруудыг тус тус татан буулгажээ.


1960-аад оны дунд үеэс манай Төр засгаас хууль ёсыг улам чангатгах, нийгэмд харш үйлдэл, үзэгдэл бүрийг илрүүлэн, хуулийн хариуцлага хүлээлгэж, хэрэгтэн этгээдийг хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх, ажлын үр нөлөөг дээшлүүлэх бодлого шийдвэр гаргасантай уялдуулан, гяндан, онцгой, чанга дэглэмтэй хорих лагериудыг Дотоодын цэргээр хамгаалуулахаар шийдвэрлэж байсан түүхтэй.

Монгол ардын хувьсгалт намын Төв Хорооны Улс төрийн товчооны 1966 оны

341 дүгээр тогтоолоор (Хүрэлбаатар, 2022, хууд. 305) урьдчилан хорих төв буюу төв шорон, Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны сайдын 1967 оны 12 дугаар 17-ны өдрийн тушаалаар (Хүрэлбаатар, 2022, хууд. 325) Хар айраг дахь хорих анги, Авдрант дахь хорих анги, мөн сайдын 1979 оны 07 дугаар сарын (Хүрэлбаатар, Монгол улсын Дотоодын цэргийн түүх, 2022, хууд. 35) 10-ны өдрийн 515 тоот тушаалаар (Хүрэлбаатар, 2022, хууд. 342) Баянзүрх дэх хорих анги, Сайд нарын зөвлөлийн 1982 оны 87 дугаар тогтоолоор (Хүрэлбаатар, 2022, хууд. 349) Зүүнхараа дахь хорих анги, Сайд нарын зөвлөлийн 1984 оны 51 дүгээр тогтоолын (Хүрэлбаатар, 2022, хууд. 352) дагуу Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны сайдын мөн оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 407 тоот тушаалаар Дүүрэн дэх хорих анги, Сайд нарын зөвлөлийн 1985 оны 301 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны сайдын 1986 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн А/5 тоот тушаалаар Багануур дахь, Дарьт дахь гяндан, онцгой болон чанга дэглэмтэй хорих ангиудын гадуур харуул, хамгаалалтыг хариуцан гүйцэтгэж байв.

Монгол Улсын Засгийн Газрын 2002 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 155 дугаар тогтоолын дагуу дотоодын цэргийн хамгаалалтад байсан гяндан, онцгой, чанга дэглэмтэй хорих ангиудын гадуур харуул, хамгаалалтыг ШШГЕГ-т шилжүүлэн өгсөн юм.

Тэгэхээр Дотоодын цэргийн байгууллага нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай нягт хамтран ажиллаж гяндан, онцгой, чанга дэглэмтэй хорих ангиудын гадуур харуул, хамгаалалтыг хариуцан гүйцэтгэж, хорих ангиудад тогтоосон дэглэм, журмыг сахиулах амаргүй үүргийг хагас зуун (55 жил) жилийн хугацаанд гүйцэтгэж байжээ.



Хүснэгт 1. Дотоодын цэргийн байгууллагын хамгаалж байсан Улсын онц чухал объект

Дөрөв. Улсын онц чухал объектын нэршил уламжлал

4.1. Дотоодын цэргийн байгууллагын алба-ажиллагаанд улсын онц чухал объект гэсэн нэр томъёог хэдэн оноос эхлэн хэрэглэж эхэлснийг судлан үзэхэд:

А. 1932 оноос эхлэн 1960-аад он хүртэл Улсын онц чухал объект болох дараах объектуудыг “Тусгай объект” хэмээн нэрлэж байсан. Үүнд:

- МАХН-ын Төв хороо, Засгийн газрын ордон;
- Маршал Х.Чойбалсангийн Их тэнгэр дэх өвлийн өргөө;
- Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Бага Хурлын Төлөөлөгчдийн дарга, Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга нарын орон байр, Баянгол дахь зуслангийн байр;

• БНМАУ-ын Улс төр, эдийн засаг, цэрэг стратеги, маш нууц баримт бичиг төвлөрсөн байгууллага, тэсэрч дэлбэрэх зүйл агуулсан газар; (Хүрэлбаатар, 2022, хууд. 182)

• Төв хорих, Цагаан хуаран, Амгалан, Хужир булан, Налайх, Мах комбинат, Зүүнхараа дахь хорих анги, Хүүхдийн колони.

Б. 1961-1962 он хүртэл “Тусгай объект” гэсэн нэр томъёог “Улсын онцгой объект” гэж нэрлэж байсан байна.

Энэ талаар НАХЯ-ны ажлын тухай авч хэлэлцээд гаргасан МАХН-ын Төв хорооны Улс Төрийн товчооны 1961 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 04 дүгээр тогтоолд “Тусгай объект” гэсэн нэр томъёог “Улсын онцгой объект” гэж нэрлэжээ.

Улсын онцгой объектод дараах объектууд хамаарч байсан байна. Үүнд:

- Тусгай объектууд;
- Их тэнгэрийн аман дахь Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хороо, Засгийн газрын 50-ын 3 дугаар зочид байр;
- Манай оронд Төр, засгийн айлчлал хийж байгаа гадаад орны төр засгийн тэргүүн, өндөр дээд хэмжээний хүндэт зочид, төлөөлөгчдийн байрлаж байгаа байр, хөлөглөж яваа онгоц, галт тэрэг, автомашин;
- Улаанбаатар хотын Нэгдүгээр цахилгаан станц зэрэг хамаарна.

В. БНМАУ-ын НАХЯ-ны дүрмийг МАХН-ын Төв хороо, Сайд нарын Зөвлөлийн 1962 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 16/550 дугаар тогтоолоор баталжээ. Энэхүү дүрэмд “Улсын онцгой объект” гэсэн нэр томъёог “Улсын чухал объект” гэж өөрчлөн заасан бөгөөд, эдгээрт дараах объектууд хамаарч байжээ. Үүнд:

- Улсын онцгой объектууд;
- Сэлэнгэ аймгийн Бугант дахь (албан баримт бичигт Толгойт гэж нэрлэг) алтны үйлдвэр;
- Хар айраг дахь хорих анги зэрэг хамаарна.

Г. НАХЯ-ны дүрэмд заасан “Улсын чухал объект” гэсэн нэр томъёог НАХЯ-ны орлогч сайд, хилийн ба дотоодын цэргийн хэрэг эрхлэх газрын даргын 1970 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар тушаалаар (Хүрэлбаатар, 2022, хууд. 319) мөн оны 5 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан Онц хилчин харуулчийн зөвлөгөөний уриалгад “Улсын чухал объект” нэр томъёог “Улсын онц чухал объект” гэж өөрчлөн нэрлэсэн. Мөн НАХЯ-



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠰᠤᠬᠢᠭᠠᠨ ᠰᠤᠬᠢᠭᠠᠨ ᠰᠤᠬᠢᠭᠠᠨ

ны коллегийн хурлаар улсын чухал объектын хамгаалалтыг сайжруулах тухай авч хэлэлцээд, баталсан 1972 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 7/26 дугаар бүхий удирдамжид Улсын онц чухал объектыг дараах гурван зэрэгт хувааж заасан байна. Үүнд:

1 дүгээр зэрэгт: Улс төр, эдийн засгийн ач холбогдлоороо дайсны анхаарлыг онцгой татах, ямар нэгэн ноцтой учрал, зөрчил гарснаар улс нийгмийн амьдрал, эдийн засагт ноцтой хохирол учруулж болох үйлдвэр, байгууллагууд А объект буюу улсын онц чухал объект;

2 дугаар зэрэгт: Эдийн засаг, улс төрийн ач холбогдлоороо дайсны анхаарлыг онцгой татахааргүй үйлдвэр байгууллагууд Б объект буюу улсын чухал объект;

3 дугаар зэрэгт: Орон нутгийн чанартай жижиг салбар, байгууллагууд В объект гэж ангилсан.

1980-аад оны эхэн хүртэл эдийн засгийн аюулгүй байдлыг хангах ажлыг улсын онц чухал объект, улсын чухал объектыг хамгаалах гэдгээр ойлгож байсан боловч, холбогдох эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, тушаал, дүрэм, заавар зэрэгт дараах байдлаар заасан байна. Үүнд:


1. НАХЯ-ны сайдын 1982 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 261 дүгээр тушаалд “Нам, улсын чухал объект”

(Хүрэлбаатар, Монгол улсын Дотоодын цэргийн түүх, 2022, хууд. 307) гэж нэрлэсэн;

2. Сайд нарын зөвлөлийн “Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит тусгай хорооны талаар авч хэрэгжүүлэх тухай” 1983 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 76 дугаар тогтоолд “Улсын чухал объект” (Хүрэлбаатар, Монгол улсын Дотоодын цэргийн түүх, 2022, хууд. 327) гэж тэмдэглэсэн;

3. Засгийн газрын 1992 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 82 дугаар тогтоолд “Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад байх объектууд” гэж тус тус нэрлэн заажээ.

Б. “Улсын онц чухал объект”-ыг нэрлэж байсан он цагуудыг түүхийн эх сурвалж, баримт бичгүүдээс судлан үзэхэд, 1922-1930-аад онд тусгайлан нэрлэгдэж байгаагүй бөгөөд, Дотоодыг хамгаалах газар, гянданг хамгаалах гэж хамгаалж байгаа байгууллагын нэрээр нь нэрлэж, 1932-1960-аад оны эхэн хүртэл “Тусгай объект”, 1960-1970-аад оны эхэн үе хүртэл “Улсын онцгой объект”, “Улсын чухал объект”, 1970-1990 он хүртэл “Нам, улсын онц чухал объект”, “Улсын чухал объект”, “Улсын онц чухал объект”, 1990 оноос өнөөг хүртэл “Улсын онц чухал объект” гэж тус тус нэрлэж байна.



Хүснэгт 2. Улсын онц чухал объектын түүхэн хөгжлийн явцад нэрлэж байсан нэршилүүд

В. “Улсын онц чухал объект” гэх нэршлийг заавар, дүрэм, хуульд баталгаажуулсан байдлыг судлан үзэхэд, НАХЯ-ны сайдын 1979 оны 01 дүгээр

тушаалаар батлагдсан Улсыг аюулаас хамгаалах газрын зааварт “БНМАУ-ын улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, цэрэг стратеги, социалист байгуулалтын

зориулалтын болон хүн амын амьжиргааны чухал ач холбогдлоороо дайсны анхаарлыг татах, хорлон сүйтгэх ажиллагаа явагдаж болзошгүй объект, газар, Зэвсэгт хүчний анги, салбар, маш нууц-онц чухал, маш нууц, нууц, баримт бичиг төвлөрсөн байгууллагуудыг “Улсын чухал объект” гэж анх удаа тодорхойлсон бол УИХ-аар 1993 онд хэлэлцэн баталсан Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 49 дүгээр зүйлд “Дотоодын цэргийн хамгаалалтад байх Улсын онц чухал объектын жагсаалтыг Засгийн газар батална” (Цагдаагийн байгууллагын тухай хууль, 1993), 1995 онд хэлэлцэн баталсан Дотоодын цэргийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэгт “Дотоодын цэргийн хамгаалалтад байх Улсын онц чухал объектын жагсаалтыг Засгийн газар батална” (Монгол Улсын Дотоодын цэргийн тухай хууль, 1995) гэж хуульчлан, Засгийн газрын 2003 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан Дотоодын цэргийн алба ажиллагааны дүрмийн 52 дугаар зүйлд “Монгол Улсын Засгийн газраас Дотоодын цэргийн хамгаалалтад байхаар тогтоосон улс орны нийгэм, эдийн засгийн онцгой ач холбогдол бүхий үйлдвэр, албан газар, байгууллага, барилга байгууламжийг Улсын онц чухал объект гэнэ” (Хүрэлбаатар, Монгол улсын Дотоодын цэргийн алба ажиллагааны дүрэм, 2003) гэж томьёолсон бол УИХ-аас 2017 оны 2 дугаар сарын 9-ний өдөр баталсан Дотоодын цэргийн тухай хуулийн 4.1.3-т “Монгол Улсын Засгийн газраас тогтоосон онцгой ач холбогдол бүхий байгууллага, үйлдвэр, барилга байгууламжийг Улсын онц чухал объект гэнэ” (Монгол улсын Дотоодын цэргийн тухай хууль, 2017) гэж өөрчлөн, найруулжээ.

Монгол Улсын хуулиудад:

- УИХ-аар 2017 онд шинэчлэн баталсан Дотоодын цэргийн тухай хуулийн 5.1.4 дэх хэсэгт “Дотоодын цэргийн хамгаалалтад байх Улсын онц чухал объектын жагсаалтыг Засгийн газар батална” (Монгол улсын Дотоодын цэргийн тухай хууль, 2017) Цагдаагийн албаны тухай хуулийн 12.2 дугаар зүйлд “Цагдаагийн байгууллагын хамгаалалтад

авах Онц чухал объектын жагсаалтыг Засгийн газар батална” (Цагдаагийн албаны тухай хууль, 2017).

Г. Улсын онц чухал объект”-ын хамгаалалт гэсэн нэр тодорхойлолтыг дүрэм, хуульд баталгаажуулсан байдлыг судлан үзэхэд, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан Дотоодын цэргийн алба ажиллагааны дүрмийн 53 дугаар зүйлд “Улсын онц чухал объектын хэвийн ажиллагааг хангах, объектыг халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалж байгаа объектод нэвтрэх /орох, гарах/ хүн тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, хамгаалалтын бүсэд тогтоосон дэглэм журмыг сахиулах зорилгоор хамгаалалтын хүч хэрэгслүүдийг ашиглан хамгаалж байгаа объектын захиргаатай хамтран зохион байгуулж байгаа цэргийн ажиллагааг Улсын онц чухал объектын хамгаалалт гэнэ” гэж, Дотоодын цэргийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т “Улсын онц чухал объектыг хэвийн ажиллагааг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалж байгаа объектод нэвтрэх хүн, эд зүйл, тээврийн хэрэгслийг шалгах, хамгаалалтын бүсэд тогтоосон дэглэм журмыг зохицуулах цогц үйл ажиллагааг “Улсын онц чухал объектын хамгаалалт гэнэ” гэж тус тус тайлбарласан ажээ.

Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад байх “Улсын онц чухал объект”-ын жагсаалтыг батлах тухай Засгийн газрын 2004 оны 135 дугаар тогтоолд анх удаа “Улсын онц чухал объект” гэж нэрлэсэн. Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 281 дүгээр тогтоолоор Дотоодын цэргийн хамгаалалтад байх Улсын онц чухал объектыг батлан мөрдөж байна. Гэвч Төрийн тусгай хамгаалалтын газрын хамгаалалтад байх объектуудыг “Улсын онц чухал объект” гэж тусгайлан зааж нэрлээгүй байгаа нь анхаарал татаж байна.

Монгол Улсын хэмжээнд улс орны нийгэм эдийн засаг, улс төрийн өндөр ач холбогдол бүхий объектуудыг Монгол Улсын хууль, Засгийн газрын тогтоолоор Цагдаагийн байгууллага, Дотоодын



МОНГОЛЫН Дотоодын Ажиллагаа



МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН СУРГАЛ

цэргийн байгууллага, Төрийн тусгай хамгаалалтын газар хариуцан хамгаалж аюулгүй байдлын ханган ажиллаж байна.

Монгол Улсын Төрийн тусгай хамгаалалтын хуульд заасны дагуу Төрийн тусгай хамгаалалтад байх объектыг Засгийн газрын 2012 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн 65 дугаар тогтоолоор тогтоосон. Үүнд:

- Засгийн газрын байрууд, яамдууд
- Үндсэн хуулийн цэцийн байр
- Архивын ерөнхий газар
- Авлигатай тэмцэх газар гэх мэт

төрийн онцгой ач холбогдол бүхий объектыг хамгаалалтад авахаар тусгасан байна.

Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад байх “Улсын онц чухал объект” гэж нэрлэсэн боловч, төрийн тусгай хамгаалалтад байх объектыг “Улсын онц чухал объект” гэж нэрлээгүй байгаагаас үзэхэд, дараах зүйлүүдийг тодруулан авч үзэх шаардлага урган гарч байна. Үүнд:

1. Улсын онц чухал объектод ямар зэрэглэлийн объектууд хамаарах, Улсын чухал объектод ямар зэрэглэлийн объект хамаарахыг тусгайлан судлан үзэх;

2. Төрийн тусгай хамгаалалтын газрын хамгаалалтын газрын хамгаалалтад байгаа объектууд “Улсын онц чухал объект”-д хамаарах эсэхийг тодотгох;

Дүгнэлт

Дотоодын цэрэг нь цаг хугацаандаа Дотоодын цэргийн байгууллага нь Монгол улсын түүхэн цаг хугацаандаа гүйцэтгэж ирсэн үүрэг, онцлог, хамгаалалтад байсан хамгаалалтын чиг үүрэг нь объектын хамгаалалтуудыг оновчтой, уян хатан тасралтгүй зохион байгуулж ирсэн уламжлалтай.

Манай улсын цэрэг-улс төрийн гадаад орчин эмзэг, тогтворгүй, хөрш орнууд төрийнхөө бодлогоор батлан хамгаалах чадавхаа бэхжүүлэхэд ихээхэн ач холбогдол өгч, шаардлагатай тохиолдолд хилийн чанадад өөрийн эрх ашгийг цэргийн хүчээр хамгаална гэдгээ аюулгүй байдлын бодлогын баримт бичгүүддээ тусгаж, улмаар хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээнүүд авч байна.

Дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлт, уул уурхай, ашигт малтмалын хууль бус олборлолт, орчны бохирдолтын уршгаар экологи, эдийн засгийн тэнцвэрт байдал алдагдаж хүн амьтны гоц халдварт өвчин, хүн амын ядуурал, интернэт орчны зохисгүй хэрэглээнээс үүдэлтэй цахим гэмт хэрэг, халдлага нэмэгдэж байгаа өнөө цаг үед Цагдаа, дотоодын цэрэг, Төрийн тусгай хамгаалалтын газрын хамгаалалтад байгаа объектуудыг судлан үзэж зэрэглэлийг шинэчлэн тогтоох шаардлагатай байна гэж үзэж байна.

Санал

Улс орны амин чухал хэрэгцээний объектууд, хүн амын амьжиргааны чухал хангамжийн объектуудын харуул, хамгаалалтын байдлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагуудаас санаачлан, холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулан, судлан үзэж

1. Улсын онц чухал объектуудын ангиллыг шинэчлэн тогтоох (аль объект нь онц чухал объект, аль объект нь чухал объект болох, зайлшгүй хамгаалалтад байх объект боловч хамгаалалтад байгаа объект байна)

2. Улсын онц чухал объектын талаар Төрөөс баримтлах бодлогын *баримт бичиг*”-ийг боловсруулж Төр засгийн түвшинд батлуулан мөрдүүлэх.

Ашигласан материал

Монгол улсын Дотоодын цэргийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №22. 4 дүгээр зүйл (Улсын Их Хурал 1995).

Монгол улсын Дотоодын цэргийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №12. 4 дүгээр зүйлийн 4.1.3 (Улсын Их Хурал 2017).

Монгол улсын Дотоодын цэргийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №12. 5 дугаар зүйлийн 5.1.4 (Улсын Их Хурал 2017).

Хүрэлбаатар, Т. (2003). *Монгол улсын Дотоодын цэргийн алба ажиллагсааны дүрэм*. Цагдаагийн ерөнхий газрын хэвлэх хэсэг.

Хүрэлбаатар, Т. (2022). *Монгол Улсын Дотоодын цэргийн түүх*. Мөнхийн үсэг.

Хүрэлбаатар, Т. (2022). *Монгол улсын Дотоодын цэргийн түүхэнд холбогдох баримт бичиг*. Мөнхийг үсэг.

Цагдаагийн албаны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №21. 12 дугаар зүйл 12.2 (Улсын Их Хурал 2017).

Цагдаагийн байгууллагын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №4. 49 дүгээр зүйл (Улсын Их Хурал 1993).



МОНГОЛЫН
Дотоодын Цэргийн
Төрийн мэдээлэл
эмхэтгэл